

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын гэрчилгээ.....	2
Аудитын тайлан.....	3
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12 Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал.....	9
Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУЕПГ	Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газар
ХЭГ	Хэрэг эрхлэх газар
НДБ	Нийгмийн даатгалын байгууллага
СБД	Сүхбаатар дүүрэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.ЦОГТБААТАР ТАНАА

2020.02.24 № 06/593
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Handwritten signature

Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Оршил

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, авлага, өр төлбөргүй байх, мөрдөж байгаа эрх зарим зүйн актыг боловсронгуй болгох, түрээсийн гэрээг шинэчлэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Цэрэнхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2/579 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын үйл ажиллагааны эрхэм зорилгоо тус улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлжээ.

Прокурорын байгууллага 2019 онд “Нийгэмд шударга ёсыг тогтоон бэхжүүлэхэд прокурорын манлайллын жил” болгох уриан дор дараах зорилтуудыг дэвшүүлсэн Үүнд:

- Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэн, хууль ёсыг чанд сахиулах, хүний эрх, эрх чөлөөг аливаа хэлбэрээр зөрчүүлэхгүй байх, дээд шатны прокурорын хяналтыг сайжруулах;
- Авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан удирдан зохион байгуулах;
- Шүүхэд төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах оролцоо, түр дүнг нэмэгдүүлэх;
- Прокурорын хараат бус байдал, хууль зүй, эдийн засаг, нийгэм, улс төрийн баталгааг ханган сайжруулах, сахилга ёс зүй, харьцааны соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг ба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн

санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 6,330,151.9 мянган төгрөгөөс тооцон 126,603.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 113,546.5 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгон авсантай холбоотой болно.

2.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 972,078.9 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, нөөцийн барааны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,909.10	3,434.70	-474.4
Урьдчилгаа	1,654.30	-	-1,654.30
Бараа материал	412,722.60	601,962.30	189,239.70
Дуусаагүй үйлдвэрлэл	2,405,875.40		-2,405,875.40
Нөөцийн бараа		2,405,875.40	2,405,875.40
Үндсэн хөрөнгө	6,112,540.90	6,956,240.90	843,700.00
Нийт хөрөнгө	8,936,702.30	9,967,513.30	1,030,811.00
Өр төлбөр	260,876.50	223,146.60	-37,729.90
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,675,825.80	9,744,366.70	1,068,540.90
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,936,702.30	9,967,513.30	1,030,811.00

Авлага дансны үлдэгдэл 474.5 мянган төгрөгөөр буурсан нь авлагын эзэн холбогдогчийг тогтоож, барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд Нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага 1,755.0 мянган, цалингийн авлага 270.5 мянган, харьяа нэгж байгууллагаас авлага 311.2 мянган төгрөгийн авлага байна. Эдгээр авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 189,239.7 мянган төгрөгөөр өссөн нь МУЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын 2019 оны А/23 дугаар тушаалаар бараа материалыг ашиглалтаас хассан, өнгөрсөн онд хийсэн аудитын зөвлөмжийн дагуу 302 толгой малыг зах зээлийн үнээр үнэлсэн, төсвийн хөрөнгөөр эргэлтийн хөрөнгө худалдан авсан болон шилжүүлж авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 843,700.0 мянган төгрөгөөр өссөн нь МУЕП-ын 2019 оны А/44 дүгээр тушаалаар төсвийн хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө худалдаж авсан болон ТӨБЗГ-ын 2018 оны 652, 528 дугаар тогтоолоор балансаас балансад үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 37,729.9 мянган төгрөгөөр буурсан нь богино болон урт хугацаат зээлийн өр төлбөрийг хуваарийн дагуу төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2018 оны 04 дүгээр сард үүссэн 201,941.1 мянган төгрөгийн өр байгаа нь нийт өр төлбөрийн 90.5 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаар болон үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авснаас шалтгаалан тайлант үеийн үр дүн 1,068, 540.9 мянган төгрөг болсонтой холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд зориулан 5,346,120.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,342,732.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь нийт батлагдсан төсвийг хэмнэсэнтэй холбоотой байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 90,771.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 58,731.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,419.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1,301.7 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 29,318.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 32,039.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,419.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,301.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Эрх бүхий зарим албан тушаалтнуудын албан ажлын хэрэгцээний гар утасны зардлын 1,301.7 мянган төгрөгийг төсвөөс төлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2.2-т "Албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх", Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5.1-д Улсын Ерөнхий прокурор уналга, холбооны хэрэгслээр хангагдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. МУЕПГ-ын ХЭГ-ын даргын тушаалаар нэр бүхий ажиллагсад сахилгын шийтгэл ногдуулсан боловч 1,419.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэл тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 29,318.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар тайлант онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 29 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Авлага барагдуулах, бараа материалыг зах зээлийн үнээр үнэлэхтэй холбоотой 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Түрээсийн гэрээтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт:

Тус газрын үндсэн хөрөнгийн тооллого хийсэн байдлыг шалгах явцад байгууллагын цайны газрыг 2019 оны 11 дүгээр сараас 3 сарын хугацаагаар ашиглуулах түрээсийн гэрээг хувь иргэнтэй байгуулж, уг гэрээний дагуу ашиглалтын төлбөрт 1,500.0 мянган төгрөгийг байгууллагад төлөхөөр заасан боловч өнөөг хүртэл төлөгдөөгүй, авлагаар бүртгээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн өөрийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын холбогдох заалттай нийцэхгүй байна.

1.1. Эрсдэл:

Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт хангалтгүй байх, холбогдох хууль эрх зүйн заалт зөрчигдөх

1.2. Өгсөн зөвлөмж:

Ашиглалтын төлбөрийг авлагаар бүртгэж, нөхөн авах, цаашид уг гэрээг сунгах тохиолдолд ТӨБЗГ-ын 2016 оны 102, 119 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцүүлэн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт:

МУЕП-ын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн Б/228 дугаар тушаалаар Аргентин улсад болох Олон улсын Прокуроруудын Холбооны ээлжит 24 дүгээр чуулганд нэр бүхий 2 ажилтан

оролцсон ба уг гадаад томилолтын зардал 24,384.2 мянган төгрөгийг Монголын Прокуроруудын холбооны дансанд 2019 оны 12 дугаар сард шилжүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д "Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль эрх зүйн заалт зөрчигдөх

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид төрийн бус байгууллагад хөрөнгө шилжүүлэхгүй байх талаар зөвлөмж өгөх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. *Балансын данстай холбоотой асуудал*

3.1. Илрүүлэлт:

МУЕПГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тулган шалгахад авлага өмнөх оноос буурсан боловч Чингэлтэй дүүргийн НДБ-тай холбоотой 3,123.4 мянган, СБД-ийн Прокурорын хэлтэстэй холбоотой 311.3 мянган төгрөгийн авлагатай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Найдваргүй авлага, өр төлбөр үүсэх, холбогдох хууль эрх зүйн заалт зөрчигдөх

3.3. Өгсөн зөвлөмж:

Оны эцэст авлага, өр төлбөр үүсгэхгүй байх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. *Дотоод хяналттай холбоотой асуудал*

4.1. Илрүүлэлт:

МУЕП-ын 2011 оны 35 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 1.2-т "Монгол Улсын Прокурорын байгууллага нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын, Төрийн албаны, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, болон энэ журмыг мөрдлөг болгон ажиллана" гэж заасан боловч дээр дурдсан хуулиуд шинэчлэгдэн батлагдсан, зарим хууль хүчингүй болсон байна. Иймд уг журмыг шинэчлэгдэн батлагдсан Төрийн албаны болон бусад холбогдох хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актуудтай нийцүүлэн шинээр боловсруулж, мөрдөх шаардлагатай байна.

4.2. Эрсдэл:

Авлага, өглөг үүсэх, тооцоо нийлээгүй байх, холбогдох эрх зүйн заалт зөрчигдөх

4.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловсруулж, мөрдөх

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор албан бичгээр ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,824,161,457.82</u>	<u>3,011,272,355.06</u>
	АВЛАГА	3,909,071.55	3,434,659.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,126,311.55	3,123,379.52
335	Бусад авлага	782,760.00	311,280.00
3351	Байгууллагаас авах авлага	782,760.00	311,280.00
34	УРЬДЧИЛГАА	1,654,300.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	1,654,300.00	-
34714	Томилолтын урьдчилгаа	1,654,300.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,818,598,086.27	601,962,323.54
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,405,875,372.00	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	225,659,960.00	297,507,880.00
354	Хангамжийн материал	182,364,754.27	251,769,443.54
35410	Бичиг хэргийн материал	6,685,950.00	20,986,410.00
35420	Аж ахуйн материал	100,994,474.27	154,282,853.54
35430	Сэлбэг хэрэгсэл	1,441,000.00	17,993,800.00
35470	Бусад хангамжийн материал	73,243,330.00	58,506,380.00
35600	Мал амьтад	4,698,000.00	52,685,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	2,405,875,372.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө		2,405,875,372.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,112,540,874.24</u>	<u>6,956,240,957.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,112,540,874.24	6,956,240,957.20
392	Биет хөрөнгө	5,431,399,214.06	6,274,476,297.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,503,248,560.00	3,509,562,260.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(120,818,323.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,917,581,331.94	2,570,998,581.94
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,279,774,222.07)	(1,205,832,406.01)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,770,854,315.57	2,137,989,096.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(792,600,327.78)	(950,115,589.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	494,242,113.60	548,168,896.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(257,437,351.03)	(282,086,650.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,179,471.70	102,179,471.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(36,139,459.87)	(44,813,822.59)
39217	Ном	9,244,782.00	9,244,782.00
393	Биет бус хөрөнгө	681,141,660.18	681,764,659.98
39301	Програм хангамж	157,075,171.94	157,875,171.94
39302	Хуримтлагдсан элэгдэл	(156,998,171.76)	(157,175,171.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	683,974,660.00	683,974,660.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,910,000.00)	(2,910,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,936,702,332.06</u>	<u>9,967,513,312.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>260,876,541.60</u>	<u>223,146,608.12</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,661,635.40	21,205,485.94
413	Өглөг	29,661,635.40	21,205,485.94

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	913,500.00	-
41350	Зээлийн хүүгийн өглөг	2,132,682.96	174,479.08
4136	Бусад өглөг	26,615,452.44	21,031,006.86
41361	Байгууллагад төлөх өглөг	26,615,452.44	21,031,006.86
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	231,214,906.20	201,941,122.18
422	Урт хугацаат зээл	231,214,906.20	201,941,122.18
4222	Гадаад валют	231,214,906.20	201,941,122.18
42223	Санхүүгийн зээл	231,214,906.20	201,941,122.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,675,825,790.46	9,744,366,704.14
51	Засгийн газрын хувь оролцоо	8,675,825,790.46	9,744,366,704.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,554,051,432.99	4,554,051,432.99
51101	Өмч: - төрийн	4,554,051,432.99	4,554,051,432.99
512	Хуримтлагдсан үр дүн	3,468,030,465.41	4,536,571,379.09
51210	Өмнөх үеийн үр дүн	3,257,935,724.82	3,468,051,849.42
51220	Тайлант үеийн үр дүн	210,094,740.59	1,068,519,529.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	653,743,892.06	653,743,892.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,936,702,332.06	9,967,513,312.26

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,540,246,710.45	6,745,845,925.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,089,886,735.14	1,395,570,125.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,089,886,735.14	1,395,570,125.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,088,221,329.14	1,394,806,659.16
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,088,221,329.14	1,394,806,659.16
120009	Бусад орлого	1,665,406.00	763,465.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,450,359,975.31	5,350,275,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,441,738,900.00	5,346,120,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,441,738,900.00	5,346,120,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	4,155,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,000,000.00	4,155,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,621,075.31	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,621,075.31	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,222,330,409.31	5,669,520,101.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,222,330,409.31	5,669,520,101.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,025,223,663.64	5,422,400,374.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,343,995,181.81	3,313,815,564.14
210101	Үндсэн цалин	3,343,995,181.81	3,228,353,364.14
210102	Нэмэгдэл	-	16,767,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	68,694,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	398,881,685.43	395,940,600.91
210201	Тэтгэврийн даатгал	398,881,685.43	395,940,600.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,878,515.20	86,250,411.71
210301	Гэрэл, цахилгаан	47,714,177.00	29,028,105.14
210302	Түлш, халаалт	42,731,371.20	38,954,868.37
210303	Цэвэр, бохир ус	6,432,967.00	18,267,438.20
2104	Хангамж, бараа материалын зардал	438,505,428.42	497,601,610.63
210401	Бичиг хэрэг	26,330,449.50	29,515,730.00

210402	Тээвэр, шатахуун	85,937,207.70	80,467,228.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	251,540,911.78	253,882,117.56
210404	Ном, хэвлэл	3,251,060.00	4,230,525.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,509,000.00	992,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,804,799.44	69,092,010.07
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	1,132,000.00	59,422,000.00
2105	Норматив зардал	18,672,050.00	50,415,740.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,672,050.00	50,415,740.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	204,500,822.00	211,100,509.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,918,730.00	79,998.00
210604	Урсгал засвар	200,582,092.00	211,020,511.00
2107	Томилолт, зочны зардал	97,948,527.00	129,964,643.24
210701	Гадаад албан томилолт	58,889,105.00	87,717,831.24
210702	Дотоод албан томилолт	28,071,200.00	40,042,312.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,988,222.00	2,204,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,471,999.11	100,717,181.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,325,000.00	39,555,548.00
210803	Даатгалын үйлчилгээ	32,702,619.11	36,491,710.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,941,700.00	2,575,753.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	737,000.00	907,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,451,300.00	9,173,500.00
210807	Газрын төлбөр	1,314,380.00	12,013,670.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	351,369,454.67	636,594,113.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,374,255.54	28,714,153.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,404,022.00	113,822,287.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	248,591,177.13	494,057,672.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,106,745.67	247,119,727.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,354,300.00	243,654,550.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	162,679,300.00	142,952,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,675,000.00	100,702,050.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,723,878.67	3,464,777.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,723,878.67	3,464,777.12
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,567.00	400.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,567.00	400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,317,916,301.14	1,076,325,823.35
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,107,821,560.55	7,806,293.68
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	123,129,202.99	6,924,293.68
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	516,000.00	882,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	984,176,357.56	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,107,821,560.55)	(7,806,293.68)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	210,094,740.59	1,068,519,529.67

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,455,432,630.00	5,350,824,248.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,693,730.00	548,448.00

120	Нийтлэг татварын бус орлого	7,693,730.00	548,448.00
120009	Бусад орлого	7,693,730.00	548,448.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,447,738,900.00	5,350,275,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,441,738,900.00	5,346,120,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,441,738,900.00	5,346,120,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	4,155,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,000,000.00	4,155,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,189,699,941.48	5,321,191,858.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,189,699,941.48	5,321,191,858.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,980,558,129.81	5,074,610,180.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,309,794,520.74	3,309,302,647.89
210101	Үндсэн цалин	2,188,866,020.74	2,234,737,269.84
210102	Нэмэгдэл	910,577,200.00	952,878,678.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	138,037,800.00	121,686,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	399,648,300.00	401,402,957.29
210201	Тэтгэврийн даатгал	267,735,300.00	274,717,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	32,978,300.00	32,319,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,382,400.00	25,855,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,595,800.00	3,871,057.29
210205	Эрүүл мэндийн даатгал	65,956,500.00	64,639,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,206,481.00	87,899,416.91
210301	Гэрэл, цахилгаан	44,628,904.00	29,028,105.14
210302	Түлш, халаалт	47,849,128.00	40,603,873.57
210303	Цэвэр, бохир ус	6,728,449.00	18,267,438.20
2104	Хангамж, бараа материалын зардал	443,814,796.48	436,237,804.90
210401	Бичиг хэрэг	25,354,149.00	29,090,480.00
210402	Тээвэр, шатахуун	85,937,207.70	80,697,228.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	251,387,673.78	253,849,122.56
210404	Ном, хэвлэл	3,397,760.00	4,343,520.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,509,000.00	992,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	76,229,006.00	67,265,454.34
2105	Норматив зардал	205,045,850.00	126,931,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	205,045,850.00	126,931,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	209,620,922.00	261,428,044.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,716,130.00	131,380.00
210604	Урсгал засвар	205,904,792.00	261,296,664.00
2107	Томилолт, зочны зардал	98,134,727.00	115,602,828.24
210701	Гадаад албан томилолт	58,802,994.00	80,195,428.24
210702	Дотоод албан томилолт	27,803,200.00	32,629,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	11,528,533.00	2,777,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,113,499.11	159,737,836.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,635,300.00	77,243,231.00
210803	Даатгалын үйлчилгээ	32,702,619.11	43,553,722.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,941,700.00	2,575,753.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	737,000.00	907,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,782,500.00	23,444,460.00
210807	Газрын төлбөр	1,314,380.00	12,013,670.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,179,033.48	176,067,245.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,727,811.48	62,586,217.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,451,222.00	113,481,027.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	209,141,811.67	246,581,677.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,389,366.00	243,116,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	162,679,300.00	142,952,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,710,066.00	100,164,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,723,878.67	3,464,777.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,723,878.67	3,464,777.12
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,567.00	400.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,567.00	400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>265,732,688.52</u>	<u>29,632,390.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	265,732,688.52	29,632,390.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	265,732,688.52	29,632,390.00
2200	Дотоод эх үүсвэрээр	265,732,688.52	29,632,390.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	265,732,688.52	29,632,390.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(265,732,688.52)</u>	<u>(29,632,390.00)</u>

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

од	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	3,872,986,772.99	742,701,547.80	3,257,935,724.82	7,873,624,045.61
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,872,986,772.99	742,701,547.80	3,257,935,724.82	7,873,624,045.61
C07	Тайлант үеийн үр дүн	681,064,660.00	0.00	210,094,740.59	891,159,400.59
D01	2018 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	4,554,051,432.99	653,743,892.06	3,468,030,465.42	8,675,825,790.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	21,384.00	21,384.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,554,051,432.99	653,743,892.06	3,468,051,849.42	8,675,847,174.47
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,068,519,529.67	1,068,519,529.67
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,554,051,432.99	653,743,892.06	4,536,571,379.09	9,744,366,704.14

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,346,120,800.00	5,342,732,990.88	3,387,809.12	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	5,346,120,800.00	5,342,732,990.88	3,387,809.12	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,105,778,300.00	5,102,390,490.88	3,387,809.12	99.9

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,309,304,700.00	3,309,302,647.89	2,052.11	100.0
Үндсэн цалин	2,234,737,300.00	2,234,737,269.84	30.16	100.0
Нэмэгдэл	952,880,700.00	952,878,678.05	2,021.95	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	121,686,700.00	121,686,700.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	403,995,800	401,402,957.29	2,592,842.71	99.4
Тэтгэврийн даатгал	274,717,200.00	274,717,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	32,319,700.00	32,319,700.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	25,855,700.00	25,855,700.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	6,463,900.00	3,871,057.29	2,592,842.71	59.9
Эрүүл мэндийн даатгал	64,639,300.00	64,639,300.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,904,100.00	87,899,416.91	4,683.09	100.0
Гэрэл, цахилгаан	33,125,600.00	29,028,105.14	4,097,494.86	87.6
Түлш, халаалт	30,327,400.00	40,603,873.57	-10,276,473.57	133.9
Цэвэр, бохир ус	24,451,100.00	18,267,438.20	6,183,661.80	74.7
Хангамж, бараа материалын зардал	436,237,900.00	436,237,804.90	95.1	100.0
Бичиг хэрэг	34,000,900.00	29,090,480.00	4,910,420.00	85.6
Тээвэр, шатахуун	94,425,900.00	80,697,228.00	13,728,672.00	85.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	271,300,000.00	253,849,122.56	17,450,877.44	93.6
Ном хэвлэл	5,971,400.00	4,343,520.00	1,627,880.00	72.7
Хог хаягдал залуулах, хортон мэргэчдийн утгал, ариутгал	895,000.00	992,000.00	-97,000	110.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,644,700.00	67,265,454.34	-37,620,754.34	226.9
Норматив зардал	126,931,400.00	126,931,400.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	126,931,400.00	126,931,400.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	278,106,900.00	289,208,354.00	-11,101,454.00	104.0
Багаж, техник, хэрэгсэл	45,234,900.00	27,911,690.00	17,323,210.00	61.7
Урсгал засвар	232,872,000.00	261,296,664.00	-28,424,664.00	112.2
Томилолт, зочны зардал	115,612,400.00	115,602,828.24	9,571.76	100.0
Гадаад томилолт	51,973,400.00	80,195,428.24	-28,222,028.24	154.3
Дотоод албан томилолт	34,576,600.00	32,629,700.00	1,946,900.00	94.4
Зочин төлөөлөгч хүлэн авах	29,062,400.00	2,777,700.00	26,284,700.00	9.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	171,408,000.00	159,737,836.00	11,670,164.00	93.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,113,200.00	77,243,231.00	10,869,969.00	87.7
Даатгалын үйлчилгээ	43,553,800.00	43,553,722.00	78	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,575,800.00	2,575,753.00	47	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	907,000.00	907,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,244,500.00	23,444,460.00	800,040.00	96.7
Газрын төлбөр	12,013,700.00	12,013,670.00	30	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	176,277,100.00	176,067,245.65	209,854.35	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	62,586,300.00	62,586,217.81	82.19	100.0

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	113,690,800.00	113,481,027.84	209,772.16	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,342,500.00	240,342,500.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	240,342,500.00	240,342,500.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	142,952,500.00	142,952,500.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	97,390,000.00	97,390,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,346,120,800.00	5,342,732,990.88	3,387,809.12	84.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,346,120,800.00	5,342,732,990.88	3,387,809.12	99.9
Улсын төсвөөс санхүүжих	5,346,120,800.00	5,342,732,990.88	3,387,809.12	99.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	154	154	-	100.0
Удирдах ажилтан	11	11	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	83	83	-	100.0
Үйлчлэх ажилтан	60	60	-	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,626,480.0
УРСГАЛ ЗАРДАЛ		4,626,480.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,852,080.0
Эд хогшил, урсгал засварын зардал		1,852,080.0
Багаж, техник, хэрэгсэл		1,852,080.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,774,400.0
Бусад урсгал шилжүүлэг		2,774,000.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,774,000.0
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		400.0
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		400.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,626,480.0
Нэмэлт санхүүжилтийн орлого		4,626,480.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,626,480.0

5.1 АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Огноо:	2020.02.20	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/71/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар			Мянган төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга		Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Эрх бүхий зарим албан тушаалтнуудын албан ажлын хэрэгцээний гар утасны зардлыг төсвөөс төлсөн.	1,301.7	Төлбөрийн акт	МУЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Нягтлан бодогч	Д.Цогтбаатар, Д.Эрдэнэбат
2	МУЕПГ-ын ХЭГ-ын даргын тушаалаар нэр бүхий ажиллагсад сахилгын шийтгэл ногдуулсан боловч мөнгөн урамшуулал олгосон.	1,419.0	Албан шаардлага	МУЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Нягтлан бодогч	Д.Цогтбаатар, Д.Эрдэнэбат
3	Тус газрын үндсэн хөрөнгийн тооллого хийсэн байдлыг шалгах явцад байгууллагын цайны газрыг 2019 оны 11 дүгээр сараас 3 сарын хугацаагаар ашиглуулах түрээсийн гэрээг хувь иргэнтэй байгуулж, уг гэрээний дагуу ашиглалтын төлбөрт 1,500.0 мянган төгрөгийг байгууллагад төлөхөөр заасан боловч өнөөг хүртэл төлөгдөөгүй, авлагаар бүртгээгүй.	1500.0	Зөвлөмж	МУЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Нягтлан бодогч	Д.Цогтбаатар, Д.Эрдэнэбат
4	МУЕП-ын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн Б/228 дугаар тушаалаар Аргентин улсад болох Олон улсын Прокуроруудын Холбооны ээлжит 24 дүгээр чуулганд УЕП-ын нэр бүхий 2 ажилтан оролцсон боловч уг гадаад томилолтын зардал 24,384.2 мянган төгрөгийг Монголын Прокуроруудын холбооны дансанд 2019 оны 12 дугаар сард шилжүүлсэн зөрчил илэрлээ.	24,384.2	Зөвлөмж	МУЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Нягтлан бодогч	Д.Цогтбаатар, Д.Эрдэнэбат
5	МУЕПГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тулган шалгахад авлага өмнөх оноос буурсан боловч Чингэлтэй дүүргийн НДБ-тай холбоотой 3,123.4 мянган, СБД-ийн Прокурорын хэлтэстэй холбоотой 311.3 мянган төгрөгийн авлагатай байна.	3,434.7	Зөвлөмж	МУЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Нягтлан бодогч	Д.Цогтбаатар, Д.Эрдэнэбат
4	МУЕП-ын 2011 оны 35 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 1.2-т "Монгол Улсын Прокурорын байгууллага нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын, Төрийн албаны, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, болон энэ журмыг мөрдлөг болгон ажиллана" гэж заасан боловч дээр дурдсан хуулиуд шинэчлэгдэн батлагдсан, зарим хууль хүчингүй болсон байна.	-	Зөвлөмж	МУЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Нягтлан бодогч	Д.Цогтбаатар, Д.Эрдэнэбат
Зөвлөмжийн дүн		32,039,6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 02

№ 01/29

Улаанбаатар хот

СЭГ- 2020/71/СТА-ТЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар хавсралтад дурдсан нэр бүхий ажиллагсад сахилгын шийтгэл ногдуулсан боловч 1,419.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.6 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэл тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилтнуудаас 1,419.0 мянган төгрөгийг суутган нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор төвлөрүүлэх,
2. Биелэлтийг Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, нягтлан бодогч Н.Эрдэнэбат нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Ц.ЦЭРЭНХҮҮ

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

Д.ЦОГТБААТАР


Д.ЭРДЭНЭБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichie_Kherez\Akt\2020\0227SAG2.Docx

000001030005

Үндэсний аудитын газрын 2020
оны 03 дугаар сарын 02-ны өдрийн
... дугаар актын хавсралт



д/д	Овог нэр	ХЭГ-ын тушаалын дугаар	Шагнал урамшууллын хэмжээ
1	С.Цогтбаяр	Б/25	140,000
2	М.Мөнхсүрэн	Б/50	300,000
3	Т.Мөнхбаатар	Б/68	300,000
4	Н.Наранбаатар	Б/86	300,000
5	Б.Гүрсэнгээ	Б/87	79,000
6	Н.Ганхуяг	Б/88	300,000
	Дүн		1,419,000



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 02 № 01/49

Улаанбаатар хот

СЭГ- 2020/71/СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зарим албан тушаалтнуудын гар утасны зардал 1,301.7 мянган төгрөгийг төсвөөс төлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"; Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2.2-т "Албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх", "Прокурорын тухай" хуулийн 59.5.1-д Улсын Ерөнхий прокурор уналга, холбооны хэрэгслээр хангагдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зарим албан тушаалтнуудын гар утасны зардлыг төсвөөс төлж байгаа асуудлыг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.
- 2.
3. Биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, нягтлан бодогч Н.Эрдэнэбат нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР *Ц.ЦЭРЭНХҮҮ* Ц.ЦЭРЭНХҮҮ

ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.ЦОГТБААТАР

НЯГТЛАН БОДОГЧ

Н.ЭРДЭНЭБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

